



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/155/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Архангай аймаг  
2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх  
аудитор: Т.Байгалмаа  
Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нэргүйбаатар  
Утас: 70332680 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Алтанчимэг  
Утас: 90060105 Цахим хаяг: Altanchimegkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.9 Завсрын аудитын үр дүн .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

## 2.Аудитын дүгнэлт



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.25 № 93  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ХҮҮХДИЙН  
6 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Х.АЗЗАЯА ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэбулган сумын хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэбулган сумын хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,986,036.80	58,394,220.20
35	БАРАА МАТЕРИАЛ	50,986,036.80	58,394,220.20
35100	Түүхий эд материал	169,930.00	4,318,500.00
35110	Тусгай зориулалттай материал	0.00	758,000.00
35130	Эм боох материал	169,930.00	3,560,500.00
35400	Хангамжийн материал	50,816,106.80	54,075,720.20
35410	Бичиг хэргийн материал	154,000.00	186,000.00
35420	Аж ахуйн материал	46,854,011.80	49,422,926.80
35440	Түлш, шатах тослох материал	645,500.00	650,118.00
35450	Барилгын засварын материал	2,719,160.00	2,484,300.00
35460	Хүнсний материал	443,435.00	1,332,375.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	647,512,056.98	633,337,591.09
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	647,512,056.98	633,337,591.09
39200	Биет хөрөнгө	621,508,931.98	607,953,216.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	612,471,400.00	612,471,400.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-24,831,523.28	-38,321,046.56
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	23,631,963.61	25,058,258.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	-9,686,741.77	-10,002,244.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,673,072.20	49,573,033.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,342,138.78	-31,419,084.71
39214	Бусад үндсэн хөрөнгө	34,800.00	34,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-34,800.00	-34,800.00
39217	Ном	592,900.00	592,900.00
39300	Биет бус хөрөнгө	26,003,125.00	25,384,375.00
39301	Програм хангамж	1,967,500.00	1,967,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-764,375.00	-1,383,125.00
39303	Бусад биет бус хөрөнгө	24,800,000.00	24,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	698,498,093.78	691,731,811.29
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	698,498,093.78	691,731,811.29
51	Засгийн газрын хувь оролцоо	698,498,093.78	691,731,811.29
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	134,904,497.00	134,904,497.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-62,338,947.74	-69,105,230.23
51210	Өмнөх үеийн үр дүн	-60,978,799.36	-62,338,947.74
51220	Тайлант үеийн үр дүн	-1,360,148.38	-6,766,282.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	625,932,544.52	625,932,544.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	698,498,093.78	691,731,811.29

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	436,228,700.00	431,861,403.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,801,000.00	7,530,903.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,801,000.00	7,530,903.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	4,605,453.00

120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	2,925,450.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	429,427,700.00	424,330,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	367,898,100.00	361,710,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	367,898,100.00	361,710,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	210,000.00	1,455,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,455,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,319,600.00	61,164,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,319,600.00	61,164,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	437,588,848.38	438,627,685.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	437,588,848.38	438,627,685.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,306,342.38	433,802,325.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,251,700.00	288,434,400.00
210101	Үндсэн цалин	209,140,800.00	206,027,600.00
210102	Нэмэгдэл	54,437,200.00	56,050,600.00
210104	Урамшуулал	26,673,700.00	26,356,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,183,900.00	38,858,300.00
210201	Тэтгэврийн даатгал	27,573,900.00	27,295,802.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,902,500.00	2,890,599.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,322,000.00	2,312,499.36
210204	Ажилгүйдлийн даатгал	580,500.00	578,099.37
210205	Эрүүл мэндийн даатгал	5,805,000.00	5,781,299.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,585,796.00	60,289,482.00
210301	Гэрэл, цахилгаан	2,093,459.00	3,014,475.00
210302	Түлш, халаалт	50,921,594.00	53,962,067.00
210303	Цэвэр, бохир ус	3,570,743.00	3,312,940.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,414,910.00	2,326,890.00
210401	Бичиг хэрэг	210,000.00	113,500.00
210404	Ном, хэвлэл	24,000.00	24,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	835,010.00	2,189,390.00
2105	Нормативт зардал	29,023,190.00	19,445,269.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	4,100,270.00
210502	Хоол, хүнс	28,842,690.00	15,305,999.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	180,500.00	39,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,674,200.00	988,770.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,424,200.00	988,770.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,266,146.38	23,459,213.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	616,500.00	56,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,072,670.60	2,423,295.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,576,975.78	20,979,918.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,282,506.00	4,825,360.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	188,300.00	1,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	188,300.00	1,200,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,091,435.00	3,625,360.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,091,435.00	3,625,360.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-1,360,148.38	-6,766,282.49

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,360,148.38	-6,766,282.49
----	--	---------------	---------------

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31- үлдэгдэл	134,904,497.00	625,932,544.52	-60,978,799.36	699,858,242.16
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	134,904,497.00	625,932,544.52	-60,978,799.36	699,858,242.16
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,360,148.38	-1,360,148.38
10	2020 оны 12-р сарын 31- үлдэгдэл	134,904,497.00	625,932,544.52	-62,338,947.74	698,498,093.78
11	2021 оны 1-р сарын 1 үлдэгдэл	134,904,497.00	625,932,544.52	-62,338,947.74	698,498,093.78
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	134,904,497.00	625,932,544.52	-62,338,947.74	698,498,093.78
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-6,766,282.49	-6,766,282.49
20	2021 оны 12-р сарын 31- үлдэгдэл	134,904,497.00	625,932,544.52	-69,105,230.23	691,731,811.29

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	429,427,700.00	424,330,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	429,427,700.00	424,330,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	367,898,100.00	361,710,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	367,898,100.00	361,710,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	210,000.00	1,455,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,455,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,319,600.00	61,164,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,319,600.00	61,164,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	429,277,700.00	422,130,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	429,277,700.00	422,130,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	424,995,194.00	417,305,140.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,251,700.00	288,434,400.00
210101	Үндсэн цалин	204,957,038.69	209,296,056.00
210102	Нэмэгдэл	59,276,973.47	54,535,684.00
210104	Урамшуулал	26,017,687.84	24,602,660.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,183,900.00	38,858,300.00
210201	Тэтгэврийн даатгал	27,573,900.00	27,295,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,902,500.00	2,890,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,322,000.00	2,312,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	580,500.00	578,100.00

210205	Эрүүл мэндийн даатгал	5,805,000.00	5,781,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,746,829.00	60,144,100.00
210301	Гэрэл, цахилгаан	2,709,459.00	3,014,475.00
210302	Түлш, халаалт	51,444,594.00	53,816,685.00
210303	Цэвэр, бохир ус	4,592,776.00	3,312,940.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,057,100.00	1,116,300.00
210401	Бичиг хэрэг	793,200.00	260,500.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	787,400.00	191,200.00
210404	Ном, хэвлэл	102,300.00	84,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	59,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,374,200.00	370,500.00
2105	Нормативт зардал	27,707,065.00	25,286,940.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	248,200.00	7,657,800.00
210502	Хоол, хүнс	26,996,165.00	17,025,340.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	462,700.00	603,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,570,000.00	1,020,500.00
210604	Урсгал засвар	2,570,000.00	1,020,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,414,200.00	1,014,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,164,200.00	1,014,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,064,400.00	1,430,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,855,400.00	1,430,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,282,506.00	4,825,360.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	188,300.00	1,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	188,300.00	1,200,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,091,435.00	3,625,360.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,091,435.00	3,625,360.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	150,000.00	2,200,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	150,000.00	2,200,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	150,000.00	2,200,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	150,000.00	2,200,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	150,000.00	2,200,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-150,000.00	-2,200,000.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	422,875,100.00	419,249,740.00	3,625,360.00	99.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	422,875,100.00	419,249,740.00	3,625,360.00	99.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	422,675,100.00	419,049,740.00	3,625,360.00	99.1

Эрдэнэбулган сумын хүүхдийн 6-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,434,400.00	288,434,400.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	206,027,600.00	209,296,056.00	-3,268,456.00	101.6
210102	Нэмэгдэл	56,050,600.00	54,535,684.00	1,514,916.00	97.3
210104	Урамшуулал	26,356,200.00	24,602,660.00	1,753,540.00	93.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,858,300.00	38,858,300.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	27,295,800.00	27,295,800.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,890,600.00	2,890,600.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,312,500.00	2,312,500.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	578,100.00	578,100.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,781,300.00	5,781,300.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,144,100.00	60,144,100.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	2,907,000.00	3,014,475.00	-107,475.00	103.7
210302	Түлш, халаалт	50,637,100.00	53,816,685.00	-3,179,585.00	106.3
210303	Цэвэр, бохир ус	6,600,000.00	3,312,940.00	3,287,060.00	50.2
2104	Хангамж, бараа материалын зардал	976,300.00	976,300.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	108,100.00	120,500.00	-12,400.00	111.5
210402	Тээвэр, шатахуун	150,000.00	150,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	217,800.00	191,200.00	26,600.00	87.8
210404	Ном, хэвлэл	68,300.00	84,800.00	-16,500.00	124.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	237,200.00	59,300.00	177,900.00	25.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	194,900.00	370,500.00	-175,600.00	190.1
2105	Нормативт зардал	28,912,300.00	25,286,940.00	3,625,360.00	87.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,657,800.00	7,657,800.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	20,650,700.00	17,025,340.00	3,625,360.00	82.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	603,800.00	603,800.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,220,500.00	3,220,500.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,200,000.00	2,200,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	1,020,500.00	1,020,500.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	699,200.00	699,200.00	0.00	100.0

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	699,200.00	699,200.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,430,000.00	1,430,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,430,000.00	1,430,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,000.00	200,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	200,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	200,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	422,875,100.00	419,249,740.00	3,625,360.00	99.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	361,710,500.00	358,085,140.00	3,625,360.00	99.0
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	361,710,500.00	358,085,140.00	3,625,360.00	99.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	61,164,600.00	61,164,600.00	0.00	100.0
320001	Орон нутгийн төсвөөс	61,164,600.00	61,164,600.00	0.00	100.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	181,044.00	225.00	180,819.00	0.1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27.00	27.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	15.00	15.00	0.00	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	170.00	170.00	0.00	100.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	170.00	170.00	0.00	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	170.00	170.00	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27.00	27.00	0.00	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	16.00	16.00	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00	0.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,455,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,455,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	455,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	140,000.00
210401	Бичиг хэрэг	140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	315,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	315,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1000000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1455400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,455,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,455,400.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэбулган сумын Хүүхдийн 6-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Алтанчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 6-р цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 5 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус цэцэрлэг нь “Эрүүл аюулгүй байдлыг ханган, халдвар хамгааллын дэглэмд нийцүүлэн хичээл, сургалтыг чанартай зохион байгуулах, хүүхэд тоглох явцдаа суралцах сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх, багш ажилчдын багаар ажиллах чадварыг дэмжих, ажлын хариуцлага, ёс зүй, хууль дүрмийг хэрэгжүүлэх, эцэг эхийн оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэнэ” гэсэн зорилготой үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын хяналтын багийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүүхдийн 6-р цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 422.8 сая төгрөгөөс 1%-иар буюу 4.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 %-иар буюу буюу 3.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 6.8 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материалын данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	51.0	58.4	7.4	0.15
Үндсэн хөрөнгө	647.5	633.3	(14.2)	-0.02
<b>Нийт хөрөнгө</b>	<b>698.5</b>	<b>691.7</b>	(6.8)	-0.01
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	698.5	691.7	(6.8)	-0.01
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>698.5</b>	<b>691.7</b>	<b>(6.8)</b>	<b>-0.01</b>

#### 3.5.1. Бараа материал эхний үлдэгдлээс 7.4 сая төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын данс нь 51.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 26.0 сая төгрөг, хандивын 2.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 21.5 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 58.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2. Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 14.2 сая төгрөг буюу 0.01 хувиар буурсан байна. Үндсэн хөрөнгө данс нь 647.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 2.2 сая төгрөгөөр, хандивын 4.6 сая төгрөгөөр нэмэгдэж, акталж устгасан 7.5 сая төгрөг, тайлант хугацаанд байгуулсан 21.0 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч 633.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.3 Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл тайлант хугацаанд 6.8 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

**Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт**

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	61.3	61.1	-0.2
Тусгай зориулалтын шилжүүлэг	367.9	361.7	-6.2
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.2	1.4	1.2
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6.8	7.6	0.8
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>436.2</b>	<b>431.8</b>	<b>-4.4</b>
Бараа үйлчилгээний зардал	433.3	433.8	0.5
Урсгал шилжүүлэг	4.3	4.8	0.5
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>437.6</b>	<b>438.6</b>	<b>1</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-1.4</b>	<b>-6.8</b>	<b>-5.4</b>

Эрдэнэбулган сумын хүүхдийн 6-р цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны үр дүн өмнөх оноос 5.4 сая сая төгрөгөөр буурсан байна.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 465.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 155.1 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 422.8 сая төгрөгөөр хянаж баталжээ. Тайлант жилд төсөвт 3 удаа өөрчлөлт орж, хүүхдийн хоолны зардал, төсвийн өөрчлөлт орсон байна.

**3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 422.8 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 61.2 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 361.7 сая төгрөгийн ийн санхүүжилт авч 419.2 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулж 3.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь хүүхдийн хоолны зардлаас 3.6 сая төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 1.5 сая төгрөг хүлээн авсны 1.0 сая төгрөг нь аймгийн ЗДТГ-аас шагнал урамшуулалд, 0.5 сая төгрөг нь БСУГ-аас ариутгал халдваргүйжүүлэлтэд зориулан ирснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Аудитын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант жилд Ковид-19 цар тахал гарсантай холбогдуулан хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаа бүрэн явагдаагүй байна. Нийт 4 сар үйл ажиллагаа явуулж хоолны зардалд 17.0 сая төгрөгийг зарцуулж, анх батлагдсанаас 56.0 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээг 92.0 хувь хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 406.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 395.9 сая төгрөгийг зарцуулж, 97.3 хувийн биелэлттэй.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

- Тайлант жилд урсгал зардлаас 3.2 сая төгрөгийн хэмнэлт гаргаж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.
- Бичиг хэргийн зардалд 0.1 сая төгрөгийг зарцуулж, томилолт болон бусад арга хэмжээний зардал гараагүй байна.
- Тогтмол зардалд 60.1 сая зарцуулсан бөгөөд тус зардлаас хэмнэлт гараагүй байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байхгүй тул судалгааг гаргаагүй байна

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах

зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүүхдийн 6-р цэцэрлэг нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 111 мэдээллийг хугацаанд, 34 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд батлагдсан төсөвт 4 удаа өөрчлөлт орж жилийн эцэст 3.6 сая төгрөгийн хэмнэлт бий болгож төсөвт буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалттай нийцэж байна.

Мөн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 43 дугаар тогтоолтой нийцүүлэн үзэхэд Хүүхдийн 6-р цэцэрлэг нь 2.2 сая төгрөгөөр тавилга, эд хогшил бэлтгэж тус тогтоолын 1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоож Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт нь холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Хүүхдийн 6-р цэцэрлэгийн 2021 оны 3-р улирлын санхүүгийн баримт завсрын аудитад хамрагдаж 0.6 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлж биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 28-ны 135 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Хүүхдийн хоолны зардалд норм тооцож байгаа эсэхийг тулган шалгах

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.5 сая төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс 1.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2.2 сая төгрөгийн зөрчилд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах 1 албан шаардлага хүргүүлээ.

Залруулагдаагүй 3.5 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдал 4.2 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

##### 4.1 Төлбөрийн акт

4.1.1 Хүүхдийн хоолны зардлаас 1.3 сая төгрөгийг төвлөрүүлэлгүй материал хэлбэрээр нөөцлөн үлдээсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo-----

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хүүхдийн 6-р цэцэрлэг					1	1.3				
Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Хүүхдийн 6-р цэцэрлэг							1	2.2	1	
<b>НИЙТ ДҮН</b>											